

Mongolian language for foreigners – Week 14
Lecture №14

Сэдэв: Монголчуудын үндэсний баяр, наадам
Topic: Mongolian National Festival - Naadam

Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх
listening, speaking, reading, writing

Mongolian National University Arts And Culture
Professor, Basbish.S

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын үндэсний баяр наадам – Mongolian National Festival – Naadam
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework



Mongolian National Broadcaster. (2020, July 11).
Үндэсний их баяр наадам [Photograph]. www.mnb.mn.
<https://www.mnb.mn/i/211746>

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест

1. Хаврын эхэн сард болдог _____ бол Монгол үндэсний хамгийн том баярын нэг.
А. Монгол наадам Б. Төлийн баяр В. Цагаан сар Г. Шинэ жил
2. Цагаан сарыг анх сүү, цагаан идээ, хоол хүнсээр элбэг байдаг _____ тэмдэглэдэг байжээ.
А. Хавар Б. Зун В. Намар Г. Өвөл
3. Цагаан сар нь хүйтэн өвлийг давж, урин дулаан хавартай золгосны баяр мөн шинэ он гарч, нэг _____ баяр юм.
А. Жил өнгөрсний Б. Нас нэмсний В. Зочин ирсний Г. Ажил дууссаны
4. Цагаан сарын баяраар хүмүүс шинэ, сайхан хувцсаа өмсөж _____ зүйлсийн талаар ярилцдаг.
 А. бэлгэтэй сайхан Б. сонин хачин В. инээдтэй хөгжилтэй Г. өөрт тохиолдсон
5. Цагаан сараар бэлддэг гол хоол хүнс нь тавгийн боов, _____, мах, цагаан идээ юм.
 А. бууз Б. гурилтай шөл В. пицца Г. шарсан тахиа

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

6. Монголчууд _____ өнгийг сайн сайхны бэлгэ тэмдэг гэж үздэг учраас шинэ оны эхний сарыг Цагаан сар гэж нэрлэдэг.
А. улаан Б. цэнхэр В. цагаан Г. ногоон
7. Цагаан сарын баяр нь _____, _____ гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ.
 А. битүүлэг, цагаалга Б. дайлах, дайлуулах В. угтах, үдэх Г. цай, хоол
8. Өвлийн адаг сарын 30-ны өдрийг _____ гэдэг.
А. сүүлчийн өдөр Б. битүүний өдөр В. шинэ жил Г. цагаан сар
9. Шинийн нэгний өглөө нар гарахад _____ эхэлнэ.
А. айлчлал Б. золголт В. зоог Г. амралт
10. Ахмад настай, хүндтэй хүмүүстэй _____ барин золгодог.
А. ном Б. мөнгө В. торго Г. хадаг

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.

1. Монголчууд хэзээнээс наадам тэмдэглэж эхэлсэн бэ?
2. Монгол наадам хэзээ болдог вэ?
3. Монгол наадам үзэж, эсвэл наадмын талаар уншиж, сонсч байсан уу? Ямар сэтгэгдэл төрсөн бэ?
4. Монголчууд наадмаа яаж тэмдэглэдэг вэ?



Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. *Аварга – champion*
2. *Азарга - ungelded*
3. *Аргамаг хүлэг – steed*
4. *Арслан – lion*
5. *Болцуут сум – ball pointed arrow*
6. *Бортого хэлбэрийн бай – cylinder target*
7. *Бүрдэх – to consist of*
8. *Гарди – Garuda bird*
9. *Даага – 2 year old horse*
10. *Давсан бөх – wrestler who won his competitor*
11. *Дэвэх – to strut /wrestlers/*
12. *Заан – elephant*
13. *Зодог – tight jacket worn by wrestlers*
14. *Их нас - stallion*
15. *Морь уралдах – to race a horse*
16. *Начин – falcon*

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning*

17. Соёолон – five – year-old horse

18. Морь сойх – to tie up a horse in order to harden it

19. Сур харваа - archery

20. Уухайлах – to say hooray

21. Уяач – race-horse trainer

22. Хангарди – Garuda

23. Харцага - Hawk

24. Хүлэг морь - steed

25. Хязаалан – four- year – old horse

26. Унаач – horse rider

27. Уран мэх – tricky trick or technique of wrestlers

28. Шонхор - falcon

29. Шувууны дэвэлт – flapping of a bird

30. Шуудаг – wrestler’s brief

31. Шүдлэн – three-year –old horse

32. Цол олгох – to give a special award

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: Их монгол, чулууны бичигт, хууль,
биет бус, даншиг наадам, төрийн, цэргийн, Ардын наадам, 1946*

Монгол төрийн их наадам (Нэгдүгээр хэсэг – Наадмын түүх)

Монгол орны зун цаг эртнээс 1) _____ уламжлалтай байв. Монгол наадмын талаар Хүннүгийн үеийн Хятад сурвалжид тэмдэглэгдсэн байдаг. Хүннүчүүд зуны дэлгэр цагт хурдан морь, хүчит бөх, сур харваагаар хурд, бяр, цэц мэргэнээ сорьдог байжээ. Бөх барилдах, нум сум харвах, морь уралдахдаа эртнээс уламжилсан дэг 2) _____ баримталж, тусгай хувцас өмсгөл өмсдөг. Шалгарч түрүүлсэн хурдан морь, хүчит бөх, мэргэн харваачид зориулан магтаал хэлж, цоллон алдаршуулж, цол чимэг олгодог.

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: Их монгол, чулууны бичигт, хууль, биет бус, даншиг наадам, төрийн, цэргийн, Ардын наадам, 1946

1206 онд 3) _____ улсыг тунхаглаж, Тэмүүжинг Чингис хаанд өргөмжилснөөс эхлэн Төрийн их ёслол, баяр наадам болгон тэмдэглэх уламжлал тогтсон. XIII зууны МНТ-д бичигдсэнээр наадам “хуран сар”-д (долоодугаар сар) болдог байжээ. Чингисийн 4) _____ Чингис хаан Сартуул улсыг байлдан дагуулаад буцах замд найрлахад Хасарын хүү Есүнгэ 330 алд (512 м) газар харвасныг тэмдэглэсэн.

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: Их монгол, чулууны бичигт, хууль, биет бус, даншиг наадам, төрийн, цэргийн, Ардын наадам, 1946

Долоон хошууны 5) _____:

1639 онд Өвөрхангай аймгийн Ширээт цагаан нуурт Түшээт хан Гомбодоржийн 5 настай хүү Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүнд өргөмжлөн, Бат-Оршил өргөх ёслол наадам хийжээ. Энэ нь Долоон хошууны даншиг наадам хэмээн алдаршсан.



Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: Их монгол, чулууны бичигт, хууль, биет бус, даншиг наадам, төрийн, цэргийн, Ардын наадам, 1946

Арван засгийн наадам:

1772 онд Хэнтий уулыг тахих их наадам болов. Үүнийг Арван засгийн наадам гэнэ. Алдаг оног хийдэг байсан Арван засгийн наадам 1912 оноос жил бүр хийдэг б) _____ наадам болжээ. Богд хаан нас барах хүртэл буюу 1925 он хүртэл Арван засгийн наадам төрийн наадам байжээ.



Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: Их монгол, чулууны бичигт, хууль, биет бус, даншиг наадам, төрийн, цэргийн, Ардын наадам, 1946

Ардын төрийн наадам:

1921 онд ардын хувьсгал ялсны дараа 1922 онд Буянт-Ухаад улсын чанартай наадмыг анх хийжээ. Үүнийг түүхэнд 7) _____ наадам гэж тэмдэглэсэн. Цэргийн наадмаар бургас цавчих зэрэг цэргийн үзүүлбэр үзүүлдэг байв. БНМАУ байгуулагдсаны дараа 1925 оны 5-р сарын 15-нд Засгийн газрын хуралдаанаас наадмыг 7-р сарын 11-нд тэмдэглэхээр шийдвэрлэжээ. Энэ үеэс "8) _____ наадам" гэж нэрлэж байгаад Монгол улс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 9) _____ оноос хойш "Ардын хувьсгал ялсны ой" гэж тодотгох болсон.

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam



Ариунболд, Ч. (2019, June 12). Үндэсний их баяр наадам [Photograph].
montsame.mn. <https://montsame.mn/mn/read/192483>



Чимгээ, Т. (2022, July 13). Монгол наадам [Photograph]. www.montsame.mn.
<https://www.montsame.mn/mn/read/300775>

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: Их монгол, чулууны бичигт, хууль,
биет бус, даншиг наадам, төрийн, цэргийн, Ардын наадам, 1946**

2003 онд УИХ “Үндэсний их баяр наадмын тухай 10) _____” баталсан. Үндэсний их баяр наадам нь улс, аймаг, нийслэл, сумын баяр наадмаас бүрддэг. Өөрөөр хэлбэл, сум болгон, аймаг болгон, хот болгон нэгэн зэрэг тэмдэглэдэг.

Жил бүрийн 7-р сарын 11-13-нд тэмдэглэдэг Монгол түмний уламжлалт баяр “Монгол наадам” 2010 онд ЮНЕСКО-гийн “Хүн төрөлхтний Соёлын 11) _____ өвийн төлөөллийн жагсаалт”-д бүртгэгдсэн.

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam



Eagle news. (2018, August 9). Нүүдэлчин монгол наадам [Photograph]. eagle.mn.
<http://eagle.mn/r/48395>



Mongolnaadam.mn 2023. (n.d.). Монгол наадам батламж [Photograph].
www.mongolnaadam.mn. <https://www.mongolnaadam.mn/page/Details/6>

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гийнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Монгол төрийн их наадам

(Хоёрдугаар хэсэг – Наадмын зохион байгуулалт)

Монгол наадам нь уран мэхээ уралдуулан бөх барилдах, шандаст аргамаг хүлгийнхээ хурд хүчийг сорин уралдуулах, цэц мэргэнээ сорьж нум сум харвах гэсэн 3 төрлөөс бүрддэг.



Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гийнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Бөхийн барилдаан:

Бөхийн барилдаан Монголын үндэсний баяр наадмын хамгийн гол хэсэг юм. Улсын баяр наадамд 256, 512, 1) _____ бөх, орон нутгийн наадамд 32, 64, 128, 256 бөх барилддаг. Барилдаан эхлэхээс өмнө бөхчүүд баруун, зүүн хэмээх хоёр 2) _____ хуваагдан зогсно. Жигүүр тус бүрийг том цолтой бөхчүүд манлайлан, бусад бөхчүүд цолныхоо эрэмбээр зогсдог. Хамгийн том цолтой нь зүүн жигүүрээ ахлах бөгөөд баруун жигүүрийн бөхчүүдийг амлан авч, барилдааныг эхлүүлнэ. Барилдах бөхийн нэрийг дуудахад 3) _____ нь малгайг нь авч үлддэг.

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam



Үндэсний баяр наадам [Photograph]. (2018, July 2). [www.inews.mn](https://www.inews.mn/a/2123).
<https://www.inews.mn/a/2123>



Эрийн гурван наадам [Photograph]. (2022, July 10). [dailypost.mn](https://dailypost.mn/2022/07/10/%D1%8D%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B3%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BD-%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B0%D0%BC/).
[https://dailypost.mn/2022/07/10/
%D1%8D%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-
%D0%B3%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BD-
%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B0%D0%
%BC/](https://dailypost.mn/2022/07/10/%D1%8D%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B3%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BD-%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B0%D0%BC/)

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гуйнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Бөхийн барилдаан:

Барилдах бөх хангарьд, харцага, шонхор шувууны дэвэлт болон ямар нэг хүчит амьтны үйл хөдөлгөөнийг дүрслэн дэвсээр барилдах газраа очно. Барилдах үед хоёр талын засуулууд өөр өөрсдийн бөхчүүдэд эсрэг талын бөхийн сул тал, ямар 4) _____ хийж унагах талаар зөвлөнө. Унасан бөх зодогныхоо бүсийг тайлж, унаснаа мэдэгдэх бөгөөд давсан бөх тахим авах ёслол хийсний дараа засуулаасаа малгайгаа авч өмсөн, дэвж явсаар наадмын их асрын голд байрлуулсан 5) _____ тойрч ёсолно.

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гийнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Улсын баяр наадмын тухай хуулинд зааснаар таваас дээш давсан бөхөд цол олгодог. Тав давсан бөхөд начин, зургаа давсан бөхөд харцага, долоо давсан бөхөд заан, найм давсан бөхөд гарьд, ес давсан бөхөд арслан, түрүүлсэн бөхөд аварга цол өгдөг. Мөн Улсын аварга цолтой бөх түрүүлбэл Улсын даян аварга цол, Улсын даян аварга түрүүлбэл Улсын 6) _____ аварга цол олгоно гэж хуульд заажээ. Монгол бөхчүүд барилдахдаа жин, насны ялгааг үл харгалзах бөгөөд тохой, өвдөг, толгой, биеийн аль ч талаар газарт хүрвэл унасанд тооцдог. Монгол бөхийн өвөрмөц нэг зүйл нь түүний хувцас өмсгөл бөгөөд бөх хүний өмсөх хувцас нь: малгай, 7) _____, _____, гутал, гутлын боолт юм.

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam



Чимэг, Б. (2019, July 12). Баяр наадам [Photograph]. gogo.mn.
<https://gogo.mn/r/242498?i=>

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гийнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Хурдан морины уралдаан:

Улсын баяр наадамд азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн 8) _____ насны ангилалд морьдыг уралдуулдаг. Их насны морьдыг барагцаалбал 25-30 км, соёолон болон азаргыг 20 км, хязааланг 18 км, шүдлэнг 15 км, даагыг 10 км орчим газраас уралдуулна. Ингэж хол замд уралдуулахын тулд 9) _____ уралдах морьдоо тусгайлан сойж бэлддэг. Хүлэг морьдын дотроос хамгийн хурдан сайныг нь сонгон авч олон хоногийн өмнөөс өвс, усыг нь тохируулан, уяж сойх бөгөөд өдөр бүр давхиулан сорьж бэлддэг. Морьдыг 6-13 насны буюу ихэнхдээ 6-8 насны хүүхэд унаж уралддаг. Учир нь холын замд уралдаж байгаа морио ядрааж цуцаахгүйн тулд 10) _____ нь хөнгөн жинтэй байх ёстой.

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Монгол түмэн минь
Сайхан наадаарай



Чимэг, Б. (2019, July 12). Баяр наадам [Photograph]. gogo.mn.
<https://gogo.mn/r/242498?i=>

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words***

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гийнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Уралдаан эхлэхэд ёслолын хувцас өмсч, туг барьсан хүн уралдах морьдыг дагуулан наадмын талбайг гурав тойрч гаран, гарааны газар луу явна. Наадмын талбайг тойрч байхад унаач хүүхдүүд 11) _____ аялж, морьдоо сэргээн зоригжуулдаг. Гарааны газарт очоод бүх морьдыг нэг шугаманд эгнүүлэн зогсоогоод тусгай дохио өгч уралдааныг эхлүүлдэг. Түрүүлсэн моринд “Түмэн эх” цол шагнадаг. Уралдааны эхэнд ирсэн таван морийг “12) _____” гэж нэрлэнэ. Учир нь эдгээр морьдыг магтан цоллож, айргаар мялаан, эзэн, унаач хүүхдүүдийг нь мөн айргаар дайлдаг.

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

Нөхөх үгс - Choose from following words: 1024, айргийн 5, мэх, зодог/шуудаг, жигүүрт, зургаан, гийнгоо, засуул, байнуудыг, уяачид, их асрын, мэргэн, дархан, унаач

Сурын харваа:

Эрийн гурван наадмын нэг төрөл нь эртний уламжлалтай сурын харваа юм. Сур харвах газрын зай нь 45 нумын буюу 75-80 м орчим газар бөгөөд нарийн зүссэн сураар сүлжиж хийсэн бортого хэлбэрийн 13) _____ (сурыг) хана, хасаа гэсэн хоёр янзаар үелэн өрөөд, болцуут сумаар хоёр тал ээлжлэн харваж цэцэн мэргэнээ сорилцоно. Мөн сур харвах үед уухайлдаг. Уухай нь харваач байгаа оносныг илэрхийлэх бөгөөд гурван удаа уухайлдаг. Сурын харваанд шалгарсан хүмүүст 14) _____ цол, чимэг олгодог. Монгол сурын харваа нь Халх, Урианхай, Буриад сурын харваа гэсэн төрлүүдтэй.

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam



Чимэг, Б. (2019, July 12). Баяр наадам [Photograph]. gogo.mn.
<https://gogo.mn/r/242498?i=>

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 3. Discuss about following questions and review your understanding

1. Эртний монгол наадмын тухай мэдээлэл хаана тэмдэглэгдэн үлдсэн бэ?
2. Түрүүлсэн бөх, морь, харваачдыг яаж шагнадаг вэ?
3. Наадмыг хэзээнээс төрийн их баяр наадам болгон тэмдэглэх болсон бэ?
4. МНТ-д наадмын талаар юу гэж бичсэн байдаг вэ?
5. Чингисийн чулууны бичигт Есүнгэний талаар юу гэж бичсэн байдаг вэ?
6. Монголчууд түүхэндээ наадмыг ямар ямар нэрээр зохион байгуулж байсан бэ?
7. Даншиг наадмыг хэзээнээс зохиож эхэлсэн бэ?
8. Арван засгийн наадмыг хэзээнээс зохиож эхэлсэн бэ?
9. Цэргийн наадмыг хэзээ зохиож байсан бэ?
10. Монгол наадмыг хэзээ 7-р сарын 11-нд зохиохоор шийдсэн бэ? Тэр үед наадмыг юу гэж нэрлэдэг байсан бэ?
11. Монгол наадмыг хэзээнээс "Ардын хувьсгал ялсны ой" гэж тодотгох болсон бэ?
12. 2010 онд наадамтай холбоотой ямар онцгой үйл явдал болсон бэ?

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 3. Discuss about following questions and review your understanding

1. Монгол наадам спортын ямар ямар төрлөөс бүрддэг вэ?
2. Улсын баяр наадмаар хэдэн бөх яаж барилддаг вэ? Ямар тохиолдолд ялсанд тооцох вэ?
3. Бөхчүүд хэд давж, ямар ямар цол авдаг вэ?
4. Бөхчүүд барилдахдаа ямар өмсгөл өмсдөг вэ?
5. Бөхчүүд барилдахаасаа өмнө үйлддэг ёслол ямар утга учиртай вэ?
6. Наадмаар уралдах морьдыг ямар ангиллаар, ямар зайнд уралдуулдаг вэ?
7. Уралдааны морьдыг ямар насны хүн унадаг вэ? Яагаад?
8. Уралдах морьдыг хэн, яаж бэлддэг вэ?
9. Сурыг ямар зайнд, яаж харвадаг вэ?
10. Сурын харвааг юу юу гэж ангилдаг вэ?

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Дасгал 4. Тохирох үгийг сонгож, өгүүлбэрийг гүйцээнэ үү.

Exercise 4. Please select the appropriate word and use it to complete the sentence correctly.

1. Энэ жил манай сумын наадамд 256 _____ барилдав.
(бөх, бөхчүүд, бөхүүд, бөх нар)
2. _____ наадмын өмнө тусгай бэлтгэл хийдэг.
(бөх, бөхчүүд, бөхүүд, бөх нар)
3. _____ хүн бөхийн мэхийг сайн мэддэг байх ёстой.
(засуул, засуулчууд, засуулууд, засуул нар)
4. Хурдан _____ гараанаасаа гарч байна.
(морь, морьчууд, мориуд, морьд, морь нар)
5. _____ олон морь түрүүлүүлбэл цол нэмдэг.
(уяач, уяачид, уяачууд, уяач нар)
6. Энэ наадамд 30 гаруй _____ иржээ.
(уяач, уяачид, уяачууд, уяач нар)

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Гэрийн даалгавар 1 Homework 1

1. Монгол төрийн их наадам нь _____ төрлөөс бүрддэг.
A. 1 Б. 2 В. 3 Г. 4
2. Улсын баяр наадмаар 256, 512, _____ бөх барилддаг.
A. 999 Б. 888 В. 1000 Г. 1024
3. Барилдах бөхийн нэрийг дуудахад _____ нь малгайг нь авч үлддэг.
A. засуул Б. дасгалжуулагч В. шүүгч Г. Үзэгч
4. Барилдаанд унасан бөх _____ бүсийг тайлж, унаснаа мэдэгдэнэ.
A. өмднийхөө Б. даашинзныхаа В. дээлнийхээ Г. зодогныхоо
5. Улсын баяр наадмын тухай хуулинд зааснаар _____ дээш давсан бөхөд цол олгодог.
A. гурваас Б. таваас В. долоогоос Г. Есөөс

Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Гэрийн даалгавар 1
Homework 1

1. Улсын баяр наадмаар түрүүлсэн бөхөд _____ цол олгодог.
А. заан Б. гарди В. арслан Г. Аварга
2. Улсын баяр наадамд азарга, их нас, _____, хязаалан, шүдлэн, даага, гэсэн 6 насны ангилалд морьдыг уралдуулдаг.
А. гүү Б. морь В. унага Г. Соёолон
3. Уралдаанд түрүүлсэн морийг “_____” цолоор шагнадаг.
А. Онцгой морь Б. Хамгийн хурдан
В. Түмэн эх Г. Нисдэг морь
4. Харваачид сур харваж, байгаа онох үед _____.
А. Уухайлдаг Б. Дуулдаг В. Хашхирдаг Г. Алга ташдаг
5. Сурын харваанд шалгарсан хүмүүст Улсын цол, чимэг олгодог.
А. Мастер Б. Мэргэн В. Тэргүүн Г. Аварга

Монголчуудын үндэсний баяр, наадам Mongolian National Festival - Naadam

Гэрийн даалгавар 2 Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн орны баяр наадмын талаар бичээрэй.
Write about the national sport festival in your country*

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Баттулга, Ч (2020). Монгол орон судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Mongolian National Broadcaster. (2020, July 11). Үндэсний их баяр наадам [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/211746>

Одончимэг, Т. (2022, June 15). Наадам [Photograph]. montsame.mn.

<https://montsame.mn/mn/read/298916>

Зул, Г. (2017, August 2). Даншиг наадам [Photograph]. www.olloo.mn.

<http://www.olloo.mn/n/45184.html>

Адъяасүрэн, Р. (2014, July 10). Баяр наадам [Photograph]. gogo.mn.

<https://gogo.mn/r/3lgnk>

Ариунболд, Ч. (2019, June 12). Үндэсний их баяр наадам [Photograph]. montsame.mn.

<https://montsame.mn/mn/read/192483>

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Чимгээ, Т. (2022, July 13). Монгол наадам [Photograph]. www.montsame.mn.

<https://www.montsame.mn/mn/read/300775>

Eagle news. (2018, August 9). Нүүдэлчин монгол наадам [Photograph]. eagle.mn.

<http://eagle.mn/r/48395>

Mongolnaadam.mn 2023. (n.d.). Монгол наадам батламж [Photograph]. www.mongolnaadam.mn.

<https://www.mongolnaadam.mn/page/Details/6>

Барамсай, Ж. (2014, July 10). Наадмын тухай дурсамж [Photograph]. gogo.mn.

<https://gogo.mn/r/63g9y>

Үндэсний баяр наадам [Photograph]. (2018, July 2). www.inews.mn.

<https://www.inews.mn/a/2123>

Эрийн гурван наадам [Photograph]. (2022, July 10). dailypost.mn.

<https://dailypost.mn/2022/07/10/%D1%8D%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD%D0%B3%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BD%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B0%D0%BC/>

Чимэг, Б. (2019, July 12). Баяр наадам [Photograph]. gogo.mn.

<https://gogo.mn/r/242498?i=>


Монголчуудын үндэсний баяр, наадам
Mongolian National Festival - Naadam

Анхаарал хандуулсанд
баярлалаа.



https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413

Дараагийн хичээл хүртэл
баяртай!



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>